



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/308

Номгон

Асхолдинг ХХК-ний эзэмшил
газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 29 дүгээр зүйлийн 29.10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч Асхолдинг ХХК-ны Баянхонгор сум, Номгон 1-р баг, Нисэхийн-2 208 тоот хаягт байрлах үйлдвэрлэлийн зориулалттай 6409006574 нэгж талбарын дугаар бүхий 20000 м.кв талбайтай эзэмшил газар нь Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 101 тогтоолоор Улсын тусгай хэрэгцээнд авсан тул хавсралтад тусгагдсан солбицлын дагуу газрын байршлыг өөрчилсүгэй.

2. Газар эзэмшигчийн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3. Эзэмшил газрын өөрчлөлтийг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Эзэмшил газраа зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч Асхолдинг ХХК-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 306 дугаар захирамжийн хавсралтын Асхолдинг ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.



ДАРГА

Э.ЭНХБАТ

626010853

Аймгийн Засаг даргын 2026 оны 5 дугаар сарын 25-ны
өдрийн 1/3.08 дугаар захирамжийн хавсралт



БАЙРШИЛ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙГАА ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ

№	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Нэгж талбарын хаяг	Газрын хэмжээ м2	Өмнөх байршлын солбицол	Өөрчилж буй байршлын солбицол
1	2	3	4	5	6	7	8
1	Асхолдинг ХХК	5265029	6409006574	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Нийсэхийн-2 208 тоот	20000	X=631696.3597 Y=5115153.4991 X=631682.2569 Y=5115211.5735 X=631649.0618 Y=5115348.2686 X=631746.6791 Y=5115369.3642 X=631793.9769 Y=5115175.0011 X=631696.3597 Y=5115153.4991	X=631598.9676 Y=5115101.6634 X=631579.5784 Y=5115190.8171 X=631677.0232 Y=5115212.0887 X=631687.7264 Y=5115214.1971 X=631686.9370 Y=5115221.1830 X=631785.0439 Y=5115238.5304 X=631798.5780 Y=5115139.0718 X=631767.7624 Y=5115133.1330 X=631598.9676 Y=5115101.6634

---oOo---

